




“ЛЭНДМН АКТИВ ТЗК” ХХК-ИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Тайлан бэлтгэсэн:

"Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК (Хөрөнгө итгэмжлэн удирдагч)

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Соёлын Төв Өргөө /14200/, 10 давхар, 1005 тоот

Утас: +976-70122346; info@uaf.mn



Гарын үсэг:

Х.Маргад-Эрдэнэ /Гүйцэтгэх захирал/

Тайланг баталсан:

Гарын үсэг:

Ө.Болортуяа /"ЛэндМН Актив ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн дарга/



Агуулга

1. ХБҮЦ-ны мэдээлэл	3
2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл.....	4
3. Төлөөлөн удирдах зөвлөл.....	5

1. ХБҮЦ-НЫ МЭДЭЭЛЭЛ

“ЛэндМН Актив ТЗК” ХХК нь 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид “СЗХ” гэх)-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (цаашид “ХБҮЦ” гэх) гаргах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд “ЛэндМН ББСБ” ХК-ийн 100 хувь эзэмшлийн охин компани юм.

2023 оны 1-р хагас жилийн эцсийн байдлаар “ЛэндМН Актив ТЗК” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) нь хараат бус 2 гишүүн, хараат 1 гишүүн, нийт 3 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн даргаар Ө.Болортуяа, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Б.Баасандорж, ТУЗ-ийн хараат гишүүнээр Ц.Ууганбаяр нар, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК ажиллаж байна.

“ЛэндМН Актив ТЗК” ХХК нь 2022 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр 4.85 тэрбум төгрөгийн дүн бүхий ХБҮЦ-ыг СЗХ-нд бүртгүүлж 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд амжилттай арилжсан бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

Хүснэгт 1. ХБҮЦ-ны ерөнхий мэдээлэл

Мэдээлэл	Үзүүлэлт
ХБҮЦ гаргагч	"ЛэндМН Актив ТЗК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011838466
Регистрийн дугаар	6888895
ХБҮЦ-ыг бүртгэсэн СЗХ-ны тогтоолын огноо	2022/09/21
ХБҮЦ-ыг бүртгэсэн авсан СЗХ-ны тогтоолын дугаар	453
ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ (төг.)	100,000
ХБҮЦ (ширхэг)	48,500
ХБҮЦ (сая төг.)	4,850
ХБҮЦ-ны хүүгийн хувь (жилийн)	17.0%
ХБҮЦ-ны үндсэн төлбөр төлөх нөхцөл	Хугацааны эцэст бүтэн дүнгээр
ХБҮЦ-ны хүү төлөх давтамж	Сар бүр
ХБҮЦ-ны хүү тооцох хоног	365 хоног

Хөрөнгө итгэмжлэн удирдагч “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК нь 2023 онд ХБҮЦ-ны хүүгийн төлбөрт 822.24 сая төгрөгийг хуваарийн дагуу төлсөн байна. ХБҮЦ-ны үлдэгдэл хугацаанд хүүгийн төлбөрийг сар бүрийн 10-ны өдөр төлөх бөгөөд үндсэн төлбөрийг хугацааны эцэст буюу 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр төлөх хуваарьтай байна.

2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл

2023 оны жилийн эцсийн байдлаар хөрөнгийн багцын хэмжээ 2022 оны эцсийн үлдэгдлээс 2.85 хувиар өссөн байна.

Хүснэгт 2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын өрөнхий шинж чанар

Хөрөнгийн багцын шинж чанар	2022.12.31	2023.12.31	Өөрчлөлт
Багцын үлдэгдэл	4,659,080,845.22	4,791,943,073.94	2.85%
Зээлийн дундаж үлдэгдэл	16,521,563.28	14,609,582.54	-11.57%
Хамгийн өндөр дүнтэй 1 зээлийн багцад эзлэх хувь	0.61%	1.12%	0.51%
Хамгийн өндөр дүнтэй 10 зээлийн багцад эзлэх хувь	5.62%	7.17%	1.55%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Хүү /жил/	30.67%	32.66%	1.99%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.ЗҮХ	89.34%	63.18%	-26.16%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Насжилт /сар/	8.09	15.99	97.62%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Үлдэгдэл хугацаа /сар/	39.26	32.94	-16.09%
Сарын дундаж төлбөрийн дүн	697,642.82	733,423.03	5.13%
Зээлдэгчдийн сарын дундаж орлого	1,998,227.74	2,233,942.01	11.80%
Зээлийн тоо	282	328	16.31%
Зээлдэгчийн төрөл	Иргэн	Иргэн	0.00%
Барьцаа хөрөнгийн төрөл	Автомашин	Автомашин	0.00%
Барьцаа хөрөнгийн үнэлгээ	6,497,500,000.00	7,885,020,000.00	21.35%
Чанаргүй зээлийн хувь	0.00%	2.26%	2.26%
Багц дахь зээлүүдийн эргэн төлөлт Үүнээс: (өсөн нэмэгдсэн дүнгээр)	388,455,563.38	4,636,975,965.53*	
Зээлийн үндсэн төлбөр	214,270,519.70	3,018,104,496.69	
Хүүгийн төлбөр	174,088,819.17	1,615,544,369.95	
Нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр	96,224.51	3,327,098.89	

*Хөрөнгийн багц дахь зээлүүдийн 2023 оны 12 дугаар сарын эргэн төлөлт болох 404.24 сая төгрөгийг гэрээний дагуу 2024 оны 01 дүгээр сарын 03-ны дотор тооцоо нийлж, баталгаажуулан хуваарьт өдөр ТЗК-д шилжүүлнэ.

2023 жилийн эцсийн байдлаар “ЛэндМН Актив ТЗК” ХХК-ийн харилцах дансны үлдэгдэл 21.3 сая төгрөг байна.

Тайлант хугацаанд “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК нь “ЛэндМН Актив ТЗК” ХХК-ийн хөрөнгийн багцад өөрчлөлт орсон талаарх мэдээллийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, СЗХ-ны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тухай журам”-ын 11.3-т заасны дагуу СЗХ-нд мэдэгдэж ажилласан.

Хүснэгт 3. ХБҮЦ-ны хөрөнгөөр багцад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл

№	Өөрчлөлт орсон мэдээлэл	Зээлийн тоо	Зээлийн дүн
1	Хаагдсан	114	-
2	Буцаан шилжүүлсэн	1	12,992,810.70
3	Багцад нэмж бүртгэсэн	161	2,949,689,016.41
	Нийт	276	2,962,681,827.11

3. Төлөөлөн удирдах зөвлөл

“ЛэндМН Актив ТЗК” ХХК-ийг “ЛэндМН ББСБ” ХК нь бүрэн эзэмшдэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь ганц хувьцаа эзэмшигч “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч) байна.

2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 22/03 тоот шийдвэрээр А.Ганбат, Ө.Болортуяа, Б.Удвал нарыг ТУЗ-ийн гишүүнээр тус тус сонгож 2022 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн ТУЗ-ийн хурлаар хараат бус гишүүн А.Ганбатыг ТУЗ-ийн даргаар томилсон.

2023 оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөр тасалбар болгон ТУЗ-ийн дарга А.Ганбат, ТУЗ-ийн гишүүн Б.Удвал нар ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн тул 2023 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 23/01, 23/02 тоот шийдвэрээр А.Ганбат болон Б.Удвал нарыг чөлөөлж 23/03 тоот шийдвэрээр Б.Баасандорж, Ц.Ууганбаяр нарыг тус тус ТУЗ-ийн гишүүдээр томиллоо.

Тайлант хугацаанд ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 3 удаа хуралдаж холбогдох тогтоолыг баталсан. Үүнд:

Хүснэгт 4. ТУЗ-ийн шийдвэр, хэрэгжилт

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
1	2023.02.01	ТУЗ-ийн даргыг сонгох тухай	ТУЗ-ийн даргаар Өлзийбат овогтой Болортуяаг сонгов.
2	2023.04.17	Жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг хүлээн зөвшөөрөх тухай	Компанийн жилийн үйл ажиллагааны тайланг хангалттай гэж дүгнэж санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хангалттай гэж дүгнэв.
3	2023.07.17	Компанийн I хагас жилийн үйл ажиллагааны тайланг батлах тухай	2023 оны I хагас жилийн үйл ажиллагааны тайланг баталж, СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт хүргүүлсэн.